



МОНГОЛ УЛС
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛ

15141 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Самбуугийн гудамж 11, Засгийн газрын 11-р байр,
Утас: 264216, Факс: 264460,
E-mail: info@csc.gov.mn

2022.11.16 № 03/2211
танай _____ -ны № _____ -т

Г ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ЭДИЙН ЗАСАГ, ХӨГЖЛИЙН ЯМНЫ
ДЭРГЭДЭХ САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ И.БАТХҮҮ ТАНАА

Тогтоол хүргүүлэх тухай

Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 11 дүгээр сарын 08-ны өдрийн хуралдаанаар Эдийн засаг, хөгжлийн ямны дэргэдэх Салбар зөвлөлийн бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай асуудлыг хэлэлцэн шийдвэрлэв.

“Салбар зөвлөлийг байгуулж бүрэлдэхүүнийг томилох тухай”, “Салбар зөвлөлийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч, нарийн бичгийн даргыг томилох тухай” Төрийн албаны зөвлөлийн 2022 оны 598, 599 дүгээр тогтоолыг үүгээр хүргүүлж байна.

Хавсралт хуудастай

ГИШҮҮН

С.ЦЭДЭНДАМБА



22005149



МОНГОЛ УЛС
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2022 оны 11 сарын 08 өдөр

Дугаар 598

Улаанбаатар хот

Г

Г

Төрийн албаны зөвлөлийн
Эдийн засаг, хөгжлийн яамны
дэргэдэх Салбар зөвлөлийг байгуулж,
бүрэлдэхүүнийг томилох тухай

Төрийн албаны тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.6 дахь хэсэг, Улсын Их Хурлын 2019 оны 2 дугаар сарын 01-ний өдрийн 17 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм”-ийн 5.11, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 9 дүгээр сарын 04-ний өдрийн 59 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 2.1, 2.4, 2.9 дэх заалтыг тус тус үндэслэн Төрийн албаны зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. Төрийн албаны зөвлөлийн Эдийн засаг, хөгжлийн яамны дэргэдэх Салбар зөвлөлийг 2022 оны 11 дүгээр сарын 08-ны өдрөөс эхлэн байгуулсугай.


2. Салбар зөвлөлийн гишүүнээр яамны Худалдаа эдийн засгийн хамтын ажиллагааны бодлогын газрын дарга И.Батхүү, Хөгжлийн нэгдсэн бодлогын газрын Хөгжлийн загвар шинэтгэлийн хэлтсийн ахлах шинжээч Х.Оюунцэцэг, Төрийн захиргааны удирдлагын газрын ахлах мэргэжилтэн Ч.Нарангэрэл нарыг 2022 оны 11 дүгээр сарын 08-ны өдрөөс томилсугай.

3. Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, төрийн албан хаагчдын ёс зүй хариуцлага, бүтээмжийг нэмэгдүүлэх ажлыг салбарын хэмжээнд зохион байгуулж, “Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн ажиллах журам”-д заасан чиг үүргийг хэрэгжүүлж ажиллахыг Салбар зөвлөлийн гишүүн И.Батхүү, Х.Оюунцэцэг, Ч.Нарангэрэл нарт үүрэг болгосугай.

4. Энэхүү тогтоолыг холбогдох албан тушаалтанд хүргүүлж, Салбар зөвлөлийн дарга, гишүүдийг арга зүйн удирдлагаар хангаж, журамд заасан чиг үүргийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн Ажлын албаны дарга (Г.Билгүүн)-д даалгасугай.

ДАРГА

Б.БААТАРЗОРИГ



22001211



МОНГОЛ УЛС
ТӨРИЙН АЛБАНЫ ЗӨВЛӨЛИЙН
ТОГТООЛ

2022 оны 11 сарын 08 өдөр

Дугаар 599

Улаанбаатар хот

Г

Г

Салбар зөвлөлийн даргын
үүргийг түр орлон гүйцэтгэгч, нарийн бичгийн
даргыг томилох тухай

Төрийн албаны тухай хуулийн 65 дугаар зүйлийн 65.6 дахь хэсэг, Улсын Их Хурлын 2019 оны 2 дугаар сарын 01-ний өдрийн 17 дугаар тогтоолоор батлагдсан “Төрийн албаны зөвлөлийн үйл ажиллагааны дүрэм”-ийн 5.6 дахь, Төрийн албаны зөвлөлийн 2019 оны 9 дүгээр сарын 04-ний өдрийн 59 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн ажиллах журам”-ын 2.4, 5.11 дэх заалтыг тус тус үндэслэн Төрийн албаны зөвлөлөөс ТОГТООХ нь:

1. Төрийн албаны зөвлөлийн Эдийн засаг, хөгжлийн яамны дэргэдэх Салбар зөвлөлийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгчээр тус яамны Худалдаа эдийн засгийн хамтын ажиллагааны бодлогын газрын дарга И.Батхүүг 2022 оны 11 дүгээр сарын 08-ны өдрөөс Коронавируст халдварт /ковид-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн үйлчлэл дуусах хүртэл хугацаанд томилсугай.

2. Эдийн засаг, хөгжлийн яамны дэргэдэх Салбар зөвлөлийн нарийн бичгийн даргаар Төрийн захиргааны удирдлагын газрын ахлах мэргэжилтэн Ч.Нарангэрэлийг 2022 оны 11 дүгээр сарын 08-ны өдрөөс томилсугай.

3. Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтийг эрчимжүүлэх, төрийн албан хаагчдын ёс зүй хариуцлага, бүтээмжийг нэмэгдүүлэх ажлыг салбарын хэмжээнд зохион байгуулж, Салбар зөвлөлийн нарийн бичгийн дарга, гишүүдийг арга зүйн удирдлагаар хангаж, “Төрийн албаны зөвлөлийн Салбар зөвлөлийн ажиллах журам”-д заасан чиг үүргийг хэрэгжүүлж ажиллахыг Салбар зөвлөлийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч (И.Батхүүг)-д үүрэг болгосугай.

4. Энэхүү тогтоолыг холбогдох албан тушаалтанд хүргүүлж, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллахыг Төрийн албаны зөвлөлийн Ажлын албаны дарга (Г.Билгүүн)-д даалгасугай.

ДАРГА



Б.БААТАРЗОРИГ

22001214